



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025. 06.20 № 3Г-1179

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлж өгөхийг хүсье.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД *[Signature]* Г.ЗАНДАНШАТАР

000254002272



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025. 06. 20 № ХЯН/1755
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалыг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000255009721



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 6/04

Төрийн срдон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Зөвшилцөх саналын тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй танилцлаа.

Монгол Улсын Ерөнхий сайдаас 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн Засгийн газрын ЗГ-1/78 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг зарчмын хувьд дэмжиж байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ

2025062016

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Г.ЗАНДАНШАТАР

ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Засгийн газар нь улс орны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэж, хүний хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, төрийн оролцоог багасгах, инновац, шинэ технологи, хиймэл оюун ухаанд суурилан төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, шат дамжлагыг бууруулж, үйл ажиллагаанд тавих хяналт, ил тод байдлыг сайжруулах, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг багасгах, хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зэрэг зорилт, арга хэмжээг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган, Улсын Их Хурлын 2024 оны 1 дүгээр тогтоолоор батлуулсан.

Олон улсын харилцаа, геополитикийн хурцадмал нөхцөл байдал хэвээр үргэлжилж байгаа энэ цаг үед худалдааны тарифын зөрчилдөөн, уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн уналтаас үүдэлтэй эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг улс орны хөгжлийн өмнө тулгамдсан томоохон сорилт, бэрхшээлийг харилцан ойлголцолд тулгуурлан зөвшилцлийн үндсэн дээр шийдвэрлэх, үндэсний эв нэгдлийг хангаж ажиллах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Энэ хүрээнд Засгийн газрын үйл ажиллагаа шуурхай, тасралтгүй байх зарчимд үндэслэн Засгийн газрын бодлогын тогтвортой байдал, залгамж чанарыг хадгалах зорилгоор өмнөх Засгийн газрын бүтцийг зарчмын хувьд хэвээр үлдээж, бүрэлдэхүүний хувьд Ерөнхий сайд, Засгийн газрын 19 гишүүнтэй ажиллахаар төлөвлөсөн.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Засгийн газрын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, “Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга”, “Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга”, “Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын

сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга"-ын албан тушаалыг Засгийн газрын бүрэлдэхүүнээс хасч байгаатай холбогдуулан Улсын Их Хурлаас 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр баталсан Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгоно.

Үүнтэй холбогдуулан дараах Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудалд доор дурдсан асуудлыг нэмж тусгана:

1.Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд "Үндэсний баялгийн сан, төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах нэгдсэн бодлого, төрийн бүтээмж, нээлттэй засаглалын түншлэл, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудал";

2.Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудалд "хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудал";

3.Сангийн сайдын эрхлэх асуудалд "хилийн бүс дэх тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх, хилийн боомтын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хилийн боомтын болон стратегийн орд газрыг холбосон дэд бүтцийн бүтээн байгуулалт, шинэчлэлийн асуудал";

4.Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудалд "хотын хэт төвлөрлийг сааруулах, нийгмийн үйлчилгээг 20 минутын дотор авах хүнд ээлтэй шинэ орчин, нөхцөлийг бүрдүүлэх бодлого зохицуулалт, авто замын түгжрэлийг бууруулах асуудал".

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна" гэж заасны дагуу Ерөнхий сайдаар томилогдохдоо дэвшүүлсэн бодлого, зорилтоо хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Мөн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан хөгжлийн мега төсөл, суурь реформ болон аялал жуулчлал, цахим засаглал, эрчим хүчний салбарын либеральчлал, дэд бүтцийн бүтээн байгуулалт, төрөлжсөн бүсүүдийн хөгжил, Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бэхжүүлэх зорилгыг бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Засгийн газрын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбогдуулан Засгийн газрын зарим гишүүний эрхлэх асуудлын хүрээний нийцлийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

---000---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д "Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ" гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Засгийн газар нь улс орны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэж, хүний хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, төрийн оролцоог багасгах, инновац, шинэ технологи, хиймэл оюун ухаанд суурилан төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, шат дамжлагыг бууруулж, үйл ажиллагаанд тавих хяналт, ил тод байдлыг сайжруулах, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг багасгах, хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зэрэг зорилт, арга хэмжээг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган, Улсын Их Хурлын 2024 оны 1 дүгээр тогтоолоор батлуулсан.

Олон улсын харилцаа, геополитикийн хурцадмал нөхцөл байдал хэвээр үргэлжилж байгаа энэ цаг үед худалдааны тарифын зөрчилдөөн, уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн уналтаас үүдэлтэй эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг улс орны хөгжлийн өмнө тулгамдсан томоохон сорилт, бэрхшээлийг харилцан ойлголцолд тулгуурлан зөвшилцлийн үндсэн дээр шийдвэрлэх, үндэсний эв нэгдлийг хангаж ажиллах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Энэ хүрээнд Засгийн газрын үйл ажиллагаа шуурхай, тасралтгүй байх зарчимд үндэслэн Засгийн газрын бодлогын тогтвортой байдал, залгамж чанарыг хадгалах зорилгоор өмнөх Засгийн газрын бүтцийг зарчмын хувьд хэвээр үлдээж, бүрэлдэхүүний хувьд Ерөнхий сайд, Засгийн газрын 19 гишүүнтэй ажиллах нь зүйтэй гэж үзсэн.

Улсын Их Хурлаас 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр баталсан Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах буюу тус хуулийн 1 дүгээр зүйлд заасан Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны даргатай холбоотой хэсгийг тус тус хүчингүй болгохоор хуулийн төсөлд тусгалаа.

Засгийн газрын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбогдуулан:

-Үндэсний баялгийн сангийн асуудал, төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах нэгдсэн бодлого, төрийн бүтээмж, нээлттэй засаглалын түншлэлийн асуудал, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын,

-хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудлыг Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын,

-хилийн бүс дэх тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх, хилийн боомтын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хилийн боомтын болон стратегийн орд газрыг холбосон дэд бүтцийн бүтээн байгуулалт, шинэчлэлийн асуудлыг Сангийн сайдын;

-хотын хэт төвлөрлийг сааруулах, нийгмийн үйлчилгээг 20 минутын дотор авах хүнд ээлтэй шинэ орчин, нөхцөлийг бүрдүүлэх бодлого зохицуулалт, авто замын түгжрэлийг бууруулах асуудлыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудалд тус тус хамааруулахаар заасан.

Түүнчлэн, дээрх өөрчлөлттэй холбогдуулан Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д өөрчлөлт оруулахаар тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна” гэж заасны дагуу Ерөнхий сайдаар томилогдохдоо дэвшүүлсэн бодлого, зорилтоо хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Мөн түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар:

-шударга ёс, баялгийн тэгш хуваарилалт, хөгжлийн мега төсөл, бүсчилсэн хөгжил зэрэг өмнөх Засгийн газрын үед хэрэгжүүлсэн томоохон бодлого, зорилтыг үргэлжлүүлэх;

-эдийн засгаа тогтворжуулж, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, үндэсний сөрөн тэсвэрлэх чадварыг бүх түвшинд төлөвшүүлэх;

-төрийн үрэлгэн зардлыг багасгаж, төр өөрөө бүсээ чангалах зарчмыг баримтлах, төсвийн сахилга батыг сахих, ил тод, нээлтэй байдлыг хангах;

-тооноос чанарт шилжиж, цомхон, чадварлаг, бүтээмжтэй төрийн албыг бий болгох;

-төрийн өмчит компаниудыг цөөлж, хувьчлалыг эрчимжүүлэх, засаглалыг сайжруулж, олон нийтийн хяналтад оруулах;

-татвар, нийгмийн даатгалын цогц реформ хийж, иргэн, аж ахуйн нэгжийн татварын дарамтыг бууруулж, шударга татварын тогтолцоог бүрдүүлэх;

-монгол хүний хөгжлийг бодлогынхоо цөмд нь, иргэдийнхээ эрхийг шийдлийнхээ голд нь тавьж асуудалд ханддаг, ард түмний төлөөх Засгийн газар байх суурь нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Засгийн газрын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах хуулийн төсөлтэй холбогдуулан Засгийн газрын зарим гишүүний эрхлэх асуудлын хүрээний нийцлийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулсан болно.

---000---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Засгийн газар нь улс орны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэж, хүний хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, төрийн оролцоог багасгах, инновац, шинэ технологи, хиймэл оюун ухаанд суурилан төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, шат дамжлагыг бууруулж, үйл ажиллагаанд тавих хяналт, ил тод байдлыг сайжруулах, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг багасгах, хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зэрэг зорилт, арга хэмжээг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган, Улсын Их Хурлын 2024 оны 1 дүгээр тогтоолоор батлуулсан.

Энэ хүрээнд Засгийн газрын үйл ажиллагаа шуурхай, тасралтгүй байх зарчимд үндэслэн Засгийн газрын бодлогын тогтвортой байдал, залгамж чанарыг хадгалах зорилгоор өмнөх Засгийн газрын бүтцийг зарчмын хувьд хэвээр үлдээж, бүрэлдэхүүний хувьд Ерөнхий сайд, Засгийн газрын 19 гишүүнтэй ажиллах нь зүйтэй гэж үзсэн.

Улсын Их Хурлаас 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр баталсан Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах буюу тус хуулийн 1 дүгээр зүйлд заасан Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны даргатай холбоотой хэсгийг тус тус хүчингүй болгохоор хуулийн төсөлд тусгалаа.

Засгийн газрын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбогдуулан, Үндэсний баялгийн сангийн асуудал, төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах нэгдсэн бодлого, төрийн бүтээмж, нээлттэй засаглалын түншлэлийн асуудал, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудлыг Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын, хилийн бүс дэх тээвэр, логиستيкийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх, хилийн боомтын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хилийн боомтын болон стратегийн орд газрыг холбосон дэд бүтцийн бүтээн байгуулалт, шинэчлэлийн асуудлыг Сангийн сайдын, хотын хэт төвлөрлийг сааруулах, нийгмийн үйлчилгээг 20 минутын дотор авах хүнд ээлтэй шинэ орчин, нөхцөлийг бүрдүүлэх бодлого зохицуулалт, авто замын түгжрэлийг бууруулах асуудлыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудалд тус тус хамааруулахаар заасан.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Засгийн газрын зарим гишүүний эрхлэх асуудлын хүрээний нийцлийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

---000---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 06 дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 6, 7, 8 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 06 дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалтын “-оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал;” гэсний дараа “-Үндэсний баялгийн сангийн асуудал; -төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах нэгдсэн бодлого; -төрийн бүтээмж, нээлттэй засаглалын түншлэлийн асуудал; -хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудал;” гэж, мөн хэсгийн 4 дэх заалтын “-төрийн захиргааны төв байгууллагын шуурхай удирдлага, салбар хоорондын бодлого, зохицуулалтын уялдааг хангах асуудал;” гэсний дараа “-хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудал;” гэж, мөн хэсгийн 9 дэх заалтын “-төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөв, санхүүгийн удирдлага болон хяналт;” гэсний дараа “-хилийн бүс дэх тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх; -хилийн боомтын хөгжлийн бодлого, төлөвлөлт; -хилийн боомтын болон стратегийн орд газрыг холбосон дэд бүтцийн бүтээн байгуулалт, шинэчлэл;” гэж, мөн хэсгийн 18 дахь заалтын “-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал;” гэсний дараа “-хотын хэт төвлөрлийг сааруулах асуудал; -нийгмийн үйлчилгээг 20 минутын дотор авах хүнд ээлтэй шинэ орчин, нөхцөлийг бүрдүүлэх бодлогын зохицуулалт; -авто замын түгжрэлийг бууруулах асуудал;” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “18³ дугаар зүйлийн 1 дэх хэсэгт” гэснийг “18⁴ дугаар зүйлийн 1 дэх хэсэгт” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 4 дэх заалтын “төрийн бүтээмж, нээлттэй засаглалын түншлэл, ” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5, 6, 7 дахь заалт, 18³ дугаар зүйл, 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт, 34² дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 06 дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗАР ДАХЬ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.4.Энэ хуулийн 3.1-д заасан этгээдээс хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, шийдвэрийг хэрэгжүүлэхэд хяналт тавих ажиллагаанд энэ хууль үйлчилнэ.”

2 дугаар зүйл.Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “хууль тогтоомжийн” гэснийг “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, шийдвэрийн” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.4 дэх заалтын “хууль тогтоомж, бодлого,” гэснийг “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг,” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргаас” гэснийг “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс” гэж, 11 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 11.1, 11.3 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын” гэснийг “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.3 дахь хэсгийн “Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргад” гэснийг “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд” гэж, 18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсгийн “Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга” гэснийг “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 06 дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын хилийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“29.2.Хилийн боомтын Үндэсний зөвлөл нь улсын хил хамгаалалтын, санхүүгийн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хилийн хяналтын байгууллага, худалдаа, аж үйлдвэрийн танхим, ложистикийн холбооны төлөөллөөс бүрдэх бөгөөд хилийн боомтын Үндэсний зөвлөлийн дарга нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.”

2 дугаар зүйл.Монгол Улсын хилийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.4, 29.5, 29.6 дахь хэсгийн “Боомтын сэргэлтийн Үндэсний хороо” гэснийг “Хилийн боомтын Үндэсний зөвлөл” гэж, мөн зүйлийн 29.3, 29.11 дэх хэсгийн “Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны” гэснийг “Хилийн боомтын Үндэсний зөвлөлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 06 дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТҮГЖРЭЛИЙГ
БУУРУУЛАХ, ГЭР ХОРООЛЛЫГ ОРОН СУУЦЖУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн 16 дугаар зүйлийн гарчгийн “Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны даргын” гэснийг “Хот байгуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний” гэж, мөн зүйлийн 16.1 дэх хэсгийн “Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга” гэснийг “хот байгуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлаар холбогдох хуулийн төслийг боловсруулсан.

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд шинэ Засгийн газар нь Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны яам, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Батлан хамгаалах яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Зам, тээврийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Эрчим хүчний яам, Эрүүл мэндийн яам гэсэн 16 яамтай, Ерөнхий сайдаас гадна 19 сайдтай ажиллахаар болсон.

Үүнтэй холбогдуулан Засгийн газрын Хяналт, үнэлгээний Үндэсний хороо, Боомтын сэргэлтийн Үндэсний хороо, 20 минутын хот Үндэсний хороо болон эдгээр хороодыг хариуцсан сайд нарыг Засгийн газрын бүрэлдэхүүнээс хасаж, эрхлэх асуудлыг холбогдох сайд нарт шилжүүлэхээр тусгасан тул улсын төсвийн зарцуулалт, удирдлага, хяналт, нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо алдагдахаас сэргийлж, төсвийн тодотголыг хийх зайлшгүй шаардлага үүсээд байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 34.1.4-д "төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх" тохиолдолд Засгийн газар тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ" гэж заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулахаар төлөвлөсөн.

Гэтэл Төсвийн тухай хуулийн 28¹.2-т заасны дагуу төсвийн тодотголын төслийн өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногт хэлэлцүүлэг зохион байгуулахаар заасан нь төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэхэд хугацаа алдах, Засгийн газар шинэ бүтэц, бүрэлдэхүүнээр шуурхай ажиллахад хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгохоор байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 28¹ дүгээр зүйлд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбоотойгоор дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах болон төсвийн тодотголын төслийг боловсруулахад төсвийн төслийн хэлэлцүүлэг хамаарахгүй байх агуулга бүхий 28¹.6 дахь хэсгийг нэмэх тухай хуулийн төслийг боловсруулан танилцуулж байна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 06 дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 28¹ дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 28^{1.6} дахь хэсэг нэмсүгэй:

“28^{1.6}.Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбоотойгоор дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон төсвийн тодотголын төслийг боловсруулахад энэ зүйлд заасан хэлэлцүүлэг хамаарахгүй.”

2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн 16.4.3 дахь заалтын “боомтын сэргэлтийн асуудал эрхэлсэн сайдын, 20 минутын хотын асуудал эрхэлсэн сайдын, хяналт, үнэлгээний асуудал эрхэлсэн сайдын ажлын албаны,” гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.8, 14.1.9, 14.1.10 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тогтвортой байдлын
тухай хуульд нэмэлт оруулах
тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлаар холбогдох хуулийн төслийг боловсруулсан.

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд шинэ Засгийн газар нь Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны яам, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Батлан хамгаалах яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Зам, тээврийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Эрчим хүчний яам, Эрүүл мэндийн яам гэсэн 16 яамтай, Ерөнхий сайдаас гадна 19 сайдтай ажиллахаар болсон.

Үүнтэй холбогдуулан Засгийн газрын Хяналт, үнэлгээний Үндэсний хороо, Боомтын сэргэлтийн Үндэсний хороо, 20 минутын хот Үндэсний хороо болон эдгээр хороодыг хариуцсан сайд нарыг Засгийн газрын бүрэлдэхүүнээс хасаж, эрхлэх асуудлыг холбогдох сайд нарт шилжүүлэхээр тусгасан тул улсын төсвийн зарцуулалт, удирдлага, хяналт, нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо алдагдахаас сэргийлж, төсвийн тодотголыг хийх зайлшгүй шаардлага үүсээд байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 34.1.4-д "төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх" тохиолдолд Засгийн газар тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ" гэж заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулахаар төлөвлөсөн.

Дэлхийн томоохон гүрнүүдийн стратегийн өрсөлдөөн гүнзгийрч, худалдаа, тарифын дайн нүүрлэсэн нэн эгзэгтэй цаг хугацаатай давхцан Ойрх дорнод, Зүүн Азийн бүс нутгийн орнуудын зэвсэгт мөргөлдөөн, Оросын Холбооны Улс болон Украины дайны нөхцөл байдал ширүүсэж, гадаад орчны тодорхой бус байдал ойрын жилүүдэд ч үргэлжлэхээр байна.

Олон улсын геополитикийн энэхүү нөхцөл байдал, худалдаа, эдийн засгийн тодорхойгүй байдлаас хамаарч, 2025 онд дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч, мөн түүхий эдийн томоохон хэрэглэгч Бүгд Найрамдах Хятад Ард Улсад үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хүндрэлээс шалтгаалан тус улсын эдийн засгийн өсөлт болон гангийн эрэлт буурч байгаа нь манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэд нөлөөлж байна.

Тухайлбал, 2025 оны эхний таван сарын байдлаар манай улсын нүүрсний экспортын дундаж үнэ тонн тутамд 71.9 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 46.6 ам.доллар буюу 39.0 хувиар буурсан нь 2025 оны төсөвт төвлөрүүлэхээр тооцсон орлогын хэмжээ 2.3 их наяд төгрөгөөр багасахад хүрээд байна.

Дэлхийн эдийн засгийн өөрчлөлттэй холбоотой нүүрсний экспортын бууралтаас шалтгаалж, төсвийн орлого төлөвлөсөн түвшнээс доогуур биелж байгаа нөхцөлд төсвийн зарлагын хэмжээг 2.3 их наяд төгрөгөөр бууруулах шаардлага үүсэж байгаа тул төсвийн тодотголыг төрийн хэмнэлтийг бүрдүүлэх, зардлыг бууруулах чиглэлд хийх нь зүйтэй байна.

Ингэхдээ төрийн чиг үүргийг оновчтой зохион байгуулж, цомхон, чадварлаг бүтцээр төрийн үйлчилгээг үр ашигтай хүргэх чиглэлээр цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх, тухайлбал, чиг үүргийн давхардлыг арилгаж, ажлын ачааллыг нягтруулах, төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг шалган баталгаажуулах, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх, төрийн өмчит хуулийн этгээдийн бүтэц, зохион байгуулалтад шинэчлэл хийх, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж хүнд суртал, шат дамжлагыг бууруулах зэрэг төрийн зардлыг хэмнэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээг төсвийн тодотголын хүрээнд авч үзнэ.

Гэтэл Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.4-т “Энэ хуульд зааснаас бусад тохиолдолд төсвийн тусгай шаардлагыг баримтлахгүйгээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах, батлах болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэхгүйгээр төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно” гэж, 7.5-д “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, түүний нэмэлт, өөрчлөлтийг баталснаас хойш гурваас доошгүй сарын хугацаанд жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэх, батлахыг хориглоно” гэж тус тус заасан нь төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэхэд хугацаа алдах, Засгийн газар шинэ бүтэц, бүрэлдэхүүнээр шуурхай ажиллахад хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгож байна.

Иймд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5, 7.6 дахь хэсэгт холбогдох нэмэлтийг оруулах тухай хуулийн төслийг боловсруулан танилцуулж байна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 06 дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн “хугацаанд” гэсний дараа “харгалзах тухайн” гэж, мөн зүйлийн 7.6 дахь хэсгийн “зорилгоор” гэсний дараа “болон Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбоотойгоор” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 06 дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн “Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал” гэсэн баганын “Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээнд” гэснийг, “Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээнд” гэснийг, “Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээнд” гэснийг тус тус хассугай.

2.Энэ тогтоолыг Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ